



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/175

Маңдалговь

Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний
зардал батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 51.2, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтын 4.11 дэх хэсэгт батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал” ажлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100431

Аймгийн Засаг даргын 2022 оны 04
сарын 22-ны өдрийн 175 дугаар
захирамжийн хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв
1	Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 15 суманд зохион байгуулах	15,000,000
2	Гамшгаас хамгаалах иргэдийн сургалтын төвийн засвар хийх	19,000,000
3	Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц хөрөнгө	20,000,000
4	Гамшгаас хамгаалах иргэдийн сургалтын төвийн материаллаг баазыг нэмэгдүүлэх	10,000,000
Нийт дүн		64,000,000